



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2019 оны 11 дүгээр сар

Ерөнхий тойм: Энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7%-иар буюу 787 сая ам.доллараар өсч 12,639 сая ам.доллар байв. Үүнд экспорт 9%-иар буюу 575 сая ам.доллараар, импорт 4%-иар буюу 212 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 363 сая ам.доллараар өсч 1,472 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 11 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	9,591	11,852	12,639	2,261	24%	787	7%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	5,686	6,481	7,056	794	14%	575	9%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	3,905	5,372	5,584	1,467	38%	212	4%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	1,782	1,109	1,472	(673)	-38%	363	33%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 131 сая ам.доллараар өсч 1,572 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 65% буюу 8,210 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 13% буюу 1,590 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 1.5%-иар буурсан бол БНХАУ-тай хийсэн худалдаа 5%-иар өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2019 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5%-иар, өмнөх сараас 6%-иар буурч 1.648-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх сараас муудахад чулуун нүүрсний хилийн үнэ өмнөх сараас буурсан болон импортын үнийн индекс өөрчлөлтгүй байсанаар тайлбарлагдаж байна.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 9%-иар буюу 575 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 9 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
1. Уул уурхай		5,047	89%		5,729	88%		6,282	89%		682	14%	12%	553	10%	9%
1.1. Эзсийн хүдэр, баяжмал	1,315	1,441	25%	1,311	1,824	28%	1,293	1,671	24%	383	27%	7%	(153)	-8%	-2%	
1.2. Чулуун нүүрс	30,981	2,111	37%	33,355	2,617	40%	34,784	2,944	42%	506	24%	9%	327	12%	5%	
1.3. Боловсруулаагүй нефть	6,940	341	6%	5,669	367	6%	5,998	335	5%	25	7%	0%	(32)	-9%	0%	
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	5,589	281	5%	6,743	308	5%	7,580	519	7%	26	9%	0%	212	69%	3%	
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	13,211	541	10%	3,432	144	2%	7,464	344	5%	(396)	-73%	-7%	200	138%	3%	
1.6. Цайрын хүдэр, баяжмал	109	165	3%	114	184	3%	125	175	2%	19	12%	0%	(8)	-5%	0%	
1.7. Жонош, лейцит, нефелинт	281	73	1%	492	166	3%	631	187	3%	93	127%	2%	21	13%	0%	
1.8. Молибдений хүдэр, баяжмал	6	34	1%	5	45	1%	5	45	1%	11	32%	0%	1	2%	0%	
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	8	0%	1	7	0%	1	6	0%	(0)	-3%	0%	(1)	-13%	0%	
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	1	0%	0	-	0%	(0)	0%	0%	(1)	-100%	0%	
1.11. Бусад	376	51	1%	484	67	1%	136	55	1%	16	31%	0%	(12)	-18%	0%	
2. Мал аж, ахуй	316	357	6%	366	450	7%	285	447	6%	93	26%	2%	(3)	-1%	0%	
2.1. Амьд мал, малын мах	23	44	1%	34	73	1%	29	61	1%	29	65%	1%	(11)	-16%	0%	
2.2. Арьс, шир	266	20	0%	305	15	0%	230	13	0%	(5)	-25%	0%	(2)	-15%	0%	
2.3. Малын өлөн гэдэс	0	6	0%	1	7	0%	0	7	0%	1	21%	0%	0	3%	0%	
2.4. Ноолуур	7	259	5%	9	326	5%	8	338	5%	67	26%	1%	12	4%	0%	
2.5. Ноос, бусад үс, хялгас	17	27	0%	14	26	0%	15	25	0%	(0)	-2%	0%	(1)	-3%	0%	
2.6. Бусад	1	2	0%	4	3	0%	3	2	0%	1	36%	0%	(1)	-26%	0%	
3. Газар тариалан	152	13	0%	45	12	0%	48	11	0%	(1)	-11%	0%	(0)	-3%	0%	
4. Аж үйлдвэрлэл	355	268	5%	203	289	4%	356	314	4%	21	8%	0%	25	9%	0%	
4.1. Хүнс	188	72	1%	29	78	1%	17	43	1%	6	8%	0%	(34)	-44%	-1%	
4.2. Ноолууран эдлэл	1	30	1%	1	33	1%	1	42	1%	3	11%	0%	9	27%	0%	
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	3	15	0%	3	23	0%	4	18	0%	9	60%	0%	(5)	-21%	0%	
4.4. Уул уурхай	33	100	2%	50	98	2%	155	104	1%	(2)	-2%	0%	6	6%	0%	
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	3	0%	0	1	0%	2	267%	0%	(2)	-74%	0%	
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	2	44	1%	3	49	1%	2	99	1%	5	11%	0%	50	103%	1%	
4.7. Бусад	300	6	0%	118	4	0%	178	7	0%	(2)	-26%	0%	2	46%	0%	
5. Бусад	1	1	0%	1	1	0%	1	1	0%	0	13%	0%	(0)	-22%	0%	
Нийт дүн		5,886		6,481			7,056			794	14%		575	9%		

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 11 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	273		280		553	10%
1.1. Эзсийн хүдэр, баяжмал	(24)	-16%	(129)	84%	(153)	-8%
1.2. Чулуун нүүрс	121	37%	206	63%	327	12%
1.3. Боловсруулаагүй нефть	18	-58%	(50)	158%	(32)	-9%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	57		154		212	69%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	186	93%	14	7%	200	138%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	15	-184%	(23)	284%	(8)	-5%
1.7. Жонош, лейцит, нефелинт	41	192%	(20)	-92%	21	13%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(2)	-191%	3	291%	1	2%
1.11. Бусад	(140)	1160%	128	-1060%	(12)	-18%
2. Мал аж, ахуй	(50)		47		(3)	-1%
2.1. Амьд мал, малын мах	(11)	95%	(1)	5%	(11)	-16%
2.2. Арьс, шир	(4)	182%	2	-82%	(2)	-15%
2.3. Малын өлөн гэдэс	(0)	-44%	0	144%	0	3%
2.4. Ноолуур	(37)	-302%	49	402%	12	4%
3. Газар тариалан	1		(1)		(0)	-3%
4. Аж үйлдвэрлэл	(22)		47		25	9%
5. Бусад	(0)		(0)		(0)	-22%
Нийт дүн	201		373		575	9%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2019 оны эхний 11 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 201 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 373 сая ам.доллараар тус тус өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 97 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 77 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалж 22 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 47 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 11 дүгээр сард 1,470 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 20%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 1.7%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,860; 85 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 5%-иар буурсан бол төмрийн хүдэр 16%-иар өссөн, зэс өмнөх сараас 1.8%-иар өссөн бол төмрийн хүдэр өмнөх сараас 4%-иар буурлаа. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 11 дүгээр сард 80 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 8%-иар өссөн бол өмнөх сараас 5%-иар буурлаа.

Импорт 2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буюу 212 сая ам.доллараар өсөв. Импортын 4 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 1 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,166	30%		1,491	28%		1,502	27%	324	28%	8%	11	1%	0%
Түргэн эдлэгтэй	767	661	17%	888	784	15%	825	777	14%	122	18%	3%	(6)	-1%	0%
Хүнс	353	459	12%	423	542	10%	392	546	10%	83	18%	2%	4	1%	0%
Эм, тариа	2	86	2%	3	107	2%	3	98	2%	21	25%	1%	(9)	-9%	0%
Бусад турзан эдлэгтэй бараа	412	117	3%	463	135	3%	430	134	2%	18	15%	0%	(1)	-1%	0%
Удаан эдлэгтэй	190	505	13%	214	707	13%	282	724	13%	202	40%	5%	18	2%	0%
Гутал, хувцас, цүнх	61	57	1%	57	69	1%	59	63	1%	12	21%	0%	(6)	-9%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	69	83	2%	84	107	2%	147	98	2%	24	29%	1%	(8)	-8%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	305	8%	2	455	8%	2	485	9%	150	49%	4%	30	7%	1%
Бусад удаан эдлэгтэй бараа	59	60	2%	71	77	1%	75	79	1%	16	27%	0%	2	3%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,020	1,510	39%	1,356	2,205	41%	1,190	2,416	43%	695	46%	18%	211	10%	4%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	24	948	24%	29	1,385	26%	26	1,613	29%	437	46%	11%	229	17%	4%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	298	8%	1	406	8%	2	532	10%	108	36%	3%	125	31%	2%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	23	649	17%	28	978	18%	24	1,082	19%	329	51%	8%	103	11%	2%
Барилгын материал	571	406	10%	739	615	11%	926	614	11%	209	51%	5%	(0)	0%	0%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	55	156	4%	42	206	4%	40	188	3%	49	31%	1%	(18)	-9%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	1,266	500	13%	1,431	664	12%	1,661	612	11%	164	33%	4%	(52)	-8%	-1%
Хүнсний орц	38	18	0%	278	77	1%	48	22	0%	59	324%	2%	(55)	-71%	-1%
Химийн бүтээгдэхүүн	168	97	2%	190	112	2%	206	110	2%	15	15%	0%	(2)	-2%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	42	21	1%	75	28	1%	74	26	0%	8	37%	0%	(3)	-10%	0%
Цахилгаан эрчим хүч	2	123	3%	1	130	2%	2	130	2%	7	6%	0%	0	0%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	2	1	0%	1	1	0%	1	1	0%	(0)	-36%	0%	0	24%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	769	240	6%	811	315	6%	860	322	6%	76	32%	2%	7	2%	0%
Нефтийн бүтээгдэхүүн	1,266	722	18%	1,431	1,006	19%	1,661	1,049	19%	284	39%	7%	43	4%	1%
Дизель түлш	736	386	10%	764	515	10%	989	612	11%	129	33%	3%	98	19%	2%
АИ-92, АИ-95	331	196	5%	333	238	4%	413	250	4%	42	21%	1%	12	5%	0%
А-80 болон бусад	199	140	4%	335	254	5%	259	187	3%	114	81%	3%	(67)	-26%	-1%
Бусад	15	7	0%	14	6	0%	200	5	0%	(1)	-8%	0%	(1)	-16%	0%
Нийт дүн		3,905		5,372			5,584		1,467	38%		212	4%		

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2019 он эхний 11 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(58)	-513%	69	613%	11	1%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	143	68%	68	32%	211	10%
Аж үйлдвэрлэлийн орц	(74)		22		(52)	-8%
Нефтийн бүтээгдэхүүн	133	309%	(90)	-209%	43	4%
Дизель түлш	139	143%	(42)	-43%	98	19%
АИ-92, АИ-95	49	401%	(36)	-301%	12	5%
А-80 болон бусад	(55)	82%	(12)	18%	(67)	-26%
Бусад	5		(6)		(1)	-16%
Нийт дүн	149	70%	63	30%	212	4%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 211 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 43 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 11 сая ам.доллараар тус тус өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 52 сая ам.доллараар буурснаар нийт импорт 212 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурсан бол өмнөх сараас 3 хувиар өсч тонн тутамд 653 ам.долларт хүрэв.